



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар A/159

Булган сум

### Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн XIV/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Аймгийн төвийн хяналтын камерыг өргөтгөх, шинэчлэх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга: Т.Баттулга

(Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд: Г.Гантулга

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө  
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

М.Мөнхбат

(Статистикийн хэлтсийн дарга)

Иргэний төлөөлөл: Б.Туяа

(Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга: Б.Эрдэнэтуяа (Орон нутгийн өмчийн газрын худалдан  
авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ

6323010109